ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2025/133/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn<br>Өмнөговь аймаг<br><br>2025 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn<br>Аудитор: Ө.Болортуяа<br>Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 110

танай ______________-ны №______________ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА
Х.ОТГОНМӨНХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Өмнөговь аймгийн хэмжээнд уст цэгийн тооллогын судалгаа, тайланг цахимжуулж мэдээллийн сан үүсгэсэн, мөн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд 263.5га талбайд 630,779 ширхэг мод тарьсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр идэвхтэй байгаль хамгаалагч нарт 57,755.5 мянган төгрөгийн 15 ширхэг мотоцикл олгож үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 106 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний

4625020269

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

хэрэгжилтийг 92 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,355,628,744.00** | **807,059,306.00** |
| **33** | **АВЛАГА** | 33,000,000.00 | 77,705,775.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 33,000,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 77,705,775.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 77,705,775.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 60,000,000.00 | 37,354,000.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 60,000,000.00 | 37,354,000.00 |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 60,000,000.00 | 37,354,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,262,628,744.00 | 691,999,531.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 868,443,065.00 | 455,547,140.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 868,443,065.00 | 455,547,140.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 361,224,579.00 | 236,452,391.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 61,588,728.00 | 42,968,728.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 7,737,041.00 | 24,649,283.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 291,898,810.00 | 168,834,380.00 |
| 35600 | Мал амьтад | 32,961,100.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **44,924,603,578.26** | **45,917,145,346.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 44,924,603,578.26 | 45,917,145,346.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,684,340,744.95 | 2,685,476,512.83 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 854,777,669.11 | 1,667,573,224.11 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -123,165,372.33 | -238,066,095.67 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 433,067,568.00 | 608,115,120.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -163,588,294.20 | -192,644,819.24 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,163,248.00 | 103,400,248.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,540,003.95 | -16,786,837.05 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 694,377,926.00 | 840,581,950.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -18,751,995.68 | -86,696,277.32 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 43,240,262,833.31 | 43,231,668,833.27 |
| 39301 | Програм хангамж | 36,576,000.00 | 36,576,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -8,313,166.69 | -16,907,166.73 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 43,212,000,000.00 | 43,212,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **46,280,232,322.26** | **46,724,204,652.10** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **46,280,232,322.26** | **46,724,204,652.10** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 46,280,232,322.26 | 46,724,204,652.10 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 43,271,820,968.48 | 43,271,820,968.48 |
| 51101 | Өмч: - төрийн | 43,260,747,908.48 | 43,260,747,908.48 |
| 51102 | - хувийн | 11,073,060.00 | 11,073,060.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,008,411,353.78 | 3,452,383,683.62 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,008,411,353.78 | 3,008,411,353.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 443,972,329.84 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **46,280,232,322.26** | **46,724,204,652.10** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,410,493,458.66** | **5,730,860,068.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,065,796,864.61** | **1,061,404,076.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,065,796,864.61 | 1,061,404,076.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,764,880.00 | 17,797,554.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 17,797,554.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 4,764,880.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,344,696,594.05** | **4,669,455,992.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,290,280,894.05 | 2,808,546,392.00 |
| 131103 | Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,221,374,844.00 | 2,080,313,392.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,000,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,800,000.05 | 728,233,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,054,415,700.00 | 1,860,909,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,054,415,700.00 | 1,860,909,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,600,253,222.72** | **5,220,369,960.72** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,600,253,222.72** | **5,220,369,960.72** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,108,920,745.02 | 4,084,922,583.37 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 657,936,847.06 | 1,240,754,599.58 |
| 210101 | Үндсэн цалин | 328,524,055.36 | 545,146,202.97 |
| 210102 | Нэмэгдэл | 251,287,050.63 | 513,448,761.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 41,115,000.00 | 86,792,443.30 |
| 210104 | Урамшуулал | 37,010,741.07 | 95,367,191.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 83,923,677.33 | 154,564,236.70 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,562,882.11 | 106,397,522.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,606,868.48 | 12,458,677.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,276,694.84 | 6,212,838.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,219,752.51 | 5,873,570.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,257,479.39 | 23,621,627.66 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 88,507,631.00 | 729,843,613.37 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,287,700.00 | 8,400,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 79,128,380.00 | 96,927,322.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,783,551.00 | 2,940,041.37 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 42,815,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 308,000.00 | 3,984,680.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 574,776,070.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 4,160,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 4,160,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,086,000.00 | 63,771,345.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,086,000.00 | 63,771,345.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 51,544,000.00 | 134,306,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 51,544,000.00 | 108,686,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 25,620,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 474,702,964.96 | 771,582,926.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 401,282,964.96 | 698,445,986.00 |
| 210807 | Газрын төлбөр | 73,420,000.00 | 73,136,940.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,740,219,624.67 | 985,939,862.72 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,382,592,484.00 | 423,527,629.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 146,456,560.00 | 225,991,520.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 211,170,580.67 | 336,420,713.72 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 491,332,477.70 | 1,135,447,377.35 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 290,865,451.80 | 876,488,197.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 198,492,500.00 | 656,359,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 102,653,197.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 92,372,951.80 | 117,475,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 200,467,025.90 | 258,959,180.35 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 200,467,025.90 | 258,959,180.35 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,810,240,235.94** | **510,490,107.28** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 104,721,416.62 | 66,517,777.44 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 104,721,416.62 | 66,517,777.44 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -104,721,416.62 | -66,517,777.44 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,705,518,819.32** | **443,972,329.84** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,344,696,594.05** | **4,720,253,546.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **17,797,554.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 17,797,554.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 17,797,554.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 17,797,554.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,344,696,594.05** | **4,702,455,992.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,290,280,894.05 | 2,841,546,392.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 60,106,050.00 | 00.00 |
| 131103 | Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,221,374,844.00 | 2,080,313,392.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,000,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,800,000.05 | 761,233,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,054,415,700.00 | 1,860,909,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,054,415,700.00 | 1,860,909,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,344,696,594.05** | **4,290,087,491.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,344,696,594.05** | **4,290,087,491.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,820,363,566.35** | **3,076,934,338.65** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 657,936,297.06 | 1,240,754,599.58 |
| 210101 | Үндсэн цалин | 328,523,505.36 | 545,146,202.97 |
| 210102 | Нэмэгдэл | 251,287,050.63 | 513,448,761.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 41,115,000.00 | 86,792,443.30 |
| 210104 | Урамшуулал | 37,010,741.07 | 95,367,191.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 83,923,677.33 | 154,564,236.70 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,562,882.11 | 106,397,522.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,606,868.48 | 12,458,677.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,276,694.84 | 6,212,838.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,219,752.51 | 5,873,570.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,257,479.39 | 23,621,627.66 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 84,634,251.00 | 169,587,457.37 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,287,700.00 | 8,400,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 75,255,000.00 | 111,447,236.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,783,551.00 | 2,940,041.37 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 42,815,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 308,000.00 | 3,984,680.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 4,160,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 4,160,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,086,000.00 | 63,781,345.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,086,000.00 | 63,781,345.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 51,544,000.00 | 134,306,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 51,544,000.00 | 108,686,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 25,620,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 593,898,280.96 | 806,436,926.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 520,478,280.96 | 733,299,986.00 |
| 210807 | Газрын төлбөр | 73,420,000.00 | 73,136,940.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 336,341,060.00 | 503,343,774.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 189,884,500.00 | 277,352,254.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 146,456,560.00 | 225,991,520.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **524,333,027.70** | **1,213,153,152.35** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 290,866,001.80 | 876,488,197.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 198,492,500.00 | 656,359,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 102,653,197.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 92,373,501.80 | 117,475,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 233,467,025.90 | 336,664,955.35 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 233,467,025.90 | 336,664,955.35 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **430,166,055.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **430,166,055.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **430,166,055.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 430,166,055.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 00.00 | 411,455,555.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 18,710,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-430,166,055.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| **2023 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 43,271,820,968.48 | 1,302,892,534.46 | 44,574,713,502.94 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **43,271,820,968.48** | **1,302,892,534.46** | 44,574,713,502.94 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,705,518,819.32 | 1,705,518,819.32 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **43,271,820,968.48** | **3,008,411,353.78** | 46,280,232,322.26 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **43,271,820,968.48** | **3,008,411,353.78** | 46,280,232,322.26 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 443,972,329.84 | 443,972,329.84 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **43,271,820,968.48** | **3,452,383,683.62** | 46,724,204,652.10 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,860,909,300.00 | 1,610,344,701.79 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,860,909,300.00 | 1,610,344,701.79 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,702,655,800.00 | 1,464,561,504.79 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,372,226,700.00 | 1,174,934,757.95 |
| 210101 | Үндсэн цалин | 593,251,800.00 | 545,146,202.97 |
| 210102 | Нэмэгдэл | 614,916,100.00 | 513,448,761.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 105,600,000.00 | 86,792,443.30 |
| 210104 | Урамшуулал | 58,458,800.00 | 29,547,350.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 171,528,000.00 | 146,455,545.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 116,639,100.00 | 100,802,835.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,722,800.00 | 11,800,479.07 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,860,800.00 | 5,883,739.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,860,800.00 | 5,568,228.87 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,444,500.00 | 22,400,261.92 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,000,000.00 | 37,589,741.37 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,400,000.00 | 8,136,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,200,000.00 | 2,940,041.37 |
| 210404 | Ном, хэвлэл | 400,000.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000,000.00 | 1,453,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 7,200,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,200,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,491,000.00 | 7,308,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,491,000.00 | 7,308,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 20,000,000.00 | 19,678,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,000,000.00 | 19,678,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 81,210,100.00 | 78,314,960.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,210,100.00 | 5,178,020.00 |
| 210807 | Газрын төлбөр | 74,000,000.00 | 73,136,940.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3000000.00 | 280000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 280,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 158253500.00 | 145783197.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 158,253,500.00 | 145,783,197.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 113,256,000.00 | 102,653,197.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 44,997,500.00 | 43,130,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,860,909,300.00 | 1,610,344,701.79 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,860,909,300.00 | 1,610,344,701.79 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,860,909,300.00 | 1,610,344,701.79 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 39.00 | 32.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 02.00 | 02.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 29.00 | 22.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 08.00 | 08.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **39.00** | **32.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 31.00 | 24.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 08.00 | 08.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **2,430,090,837.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,430,090,837.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 1,613,285,779.86 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 65,819,841.63 |
| 210104 | Урамшуулал | | 65,819,841.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 8,108,691.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 5,594,686.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 658,198.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 329,099.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 305,341.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 1,221,365.74 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 131,997,716.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 264,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 86,447,236.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 42,755,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,531,480.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | 4,160,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 4,160,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 75,183,345.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 18,710,500.00 |
| 210604 | Урсгал засвар | | 56,472,845.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 114,628,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 89,008,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | 25,620,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 728,121,966.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 728,121,966.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 485266220.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 259,554,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 225,711,520.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 730705000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 730,705,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 656,359,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 74,345,500.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **86,100,057.14** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 86,100,057.14 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **411,455,555.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 411,455,555.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 411,455,555.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 2841546392.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 2,841,546,392.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,122,129,392.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 719,417,000.00 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 57,767.4 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Хөрөнгийн тайлангийн тусламж хандиваар авсан дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнтэй тулгахад 720.900 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлын дүнг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдаж авсан хөрөнгийн дүнтэй тулгахад 18,710.500 төгрөгийг зөрүүтэй илэрхийлсэн;
- Тайлант хугацаанд 788.421 төгрөгийн Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг авлагаар тайлагнаагүй;
- Тайлант онд урсгал засварын зардлаас 00-45ӨМҮ дугаартай Ланд крузер-200 автомашинд 19,750.000 төгрөгийн засвар хийж гүйцэтгэсэн боловч капиталжуулж бүртгээгүй;
- "Ахмадын сан"-ийн 17,797.5 мянган төгрөгийн орлого, зарлагыг тайланд тусгаагүй байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 26,471.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 36,418.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг түүвэрлэн шалгахад 25,000.000 төгрөгийн шатахууныг шууд гэрээгээр худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Засгийн газрын 2024 оны “*Босго үнэ шинэчлэн батлах тухай*” 02 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Цалингийн сангаас нягтлан бодогчид балансын урамшуулал 1,471.000 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах*" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах тухай албан шаардлага хүргүүлсэн.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлөвлөлттэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт 1:</u>* Тайлант онд даргын Б/12а, Б/15а дугаартай тушаалын дугаарыг давхардуулан нөхөж гаргасан байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж оны эхнээс дэс дугаарыг зөв дугаарлан, давхардуулахгүй байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөрөнгийн тайлангийн тусламж хандиваар авсан дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнтэй тулгахад 720.900 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн | 1 | 720.9 | | | 1 | 720.9 | 1 | 720.9 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлын дүнг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдаж авсан хөрөнгийн дүнтэй тулгахад 18,710.500 төгрөгийг зөрүүтэй илэрхийлсэн | 1 | 18,710.5 | | | 1 | 18,710.5 | 1 | 18,710.5 | | | | |
| Тайлант хугацаанд 788.421 төгрөгийн Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг авлагаар тайлагнаагүй | 1 | 788.4 | 1 | 788.4 | | | 1 | 788.4 | | | | |
| Тайлант онд урсгал засварын зардлаас 0045-ӨМҮ дугаартай Ланд крузер-200 автомашинд 19,750.000 төгрөгийн засвар хийж гүйцэтгэсэн боловч капиталжуулж бүртгээгүй | 1 | 19,750.0 | 1 | 19,750.0 | | | 1 | 19,750.0 | | | | |
| "Ахмадын сан"-ийн орлого, зарлагыг тайланд тусгаагүй | 1 | 17,797.5 | 1 | 17,797.5 | | | 1 | 17,797.5 | | | | |
| **Дүн** | **5** | **57,767.4** | **3** | **38,336.0** | **2** | **19,431.4** | **5** | **57,767.4** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 25,000.000 төгрөгийн шатахууныг шууд гэрээгээр худалдан авсан байна. | 1 | 25,000.0 | | | 1 | 25,000.0 | | | | | | |
| Цалингийн сангаас нягтлан бодогчид балансын урамшуулал 1,471.000 төгрөгийг олгосон | 1 | 1,471.0 | | | 1 | 1,471.0 | | | | | | |
| Даргын Б/12а, Б/15а дугаартай тушаалын дугаарыг давхардуулан нөхөж гаргасан | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **3** | **26,471.0** | | | **2** | **26,471.0** | **1** | **0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | |
| | | | | | | |
| **Дүн** | | | | | | |